



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.1.9. ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т сар бүр мөнгөн тусламж үзүүлэх;”

2 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтын “гавьяат болон” гэснийг, мөн зүйлийн 5.1.11 дэх заалтын “-5.1.9” гэснийг тус тус хассугай

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ